

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР №22

Хуралдаан 2013 оны долдугаар сарын 9-ний өдрийн 14 цаг 05 минутад эхэлж, 16 цаг 01 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 56 минут үргэлжлэв.

| № | Хэлэлцсэн асуудал   | Гарсан шийдвэр   |
|---|---|--|
| 1 | <p>Зарим удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p> <ul style="list-style-type: none"><li>- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга</li><li>- Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Шинэчлэлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга</li></ul> | <p>Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Халзангийн Балжмаа, Халтархүүгийн Эрдэнэчулуун нарыг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.</li><li>2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан иргэдээс Халтархүүгийн Эрдэнэчулууныг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын албан тушаалыг түр орлон гүйцэтгэгч Ч.Сайнбилэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</li></ol> |

|   |  |   |
|---|--|---|
|   |  | <p>Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Бавуужавын Мягмарнаран, Энхтайваны Золбаяр нарыг Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.</p> <p>2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан иргэдээс Бавуужавын Мягмарнаранг Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 2 | <p>Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> | <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p>  |

|   |  |  |
|---|--|--|
|   |  | <p>Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд Рагчаагийн Гансүхэд дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>   |
| 3 | <p>Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай</p> | <p>Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтангэрэлийн 2013 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 2/2408 тоот албан бичиг, захиалгаар Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 8 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулахаар тогтов.</p> <p>Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга О.Магнайгийн 2013 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 1/785 тоот албан бичиг, захиалгаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон</p> |

|   |  |  |
|---|--|--|
|   |  | шалгаруулалтыг 2013 оны 8 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулахаар тогтов.   |
| 4 | Нийслэл, аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг томилох тухай | <p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, 1.4-д тус тус заасныг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 9 -ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад зааснаар тус тус батлах.</li> <li>2. Аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарыг энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад зааснаар тус тус томилох.</li> <li>3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай”, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 73 дугаар тогтоолын 1, 2, 4 дүгээр заалт, 117, 2011 оны 42, 48, 87, 128, 2012 оны 07, 11, 38, 127, 2013 оны 76 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</li> </ol> |

|          |  |  |
|----------|--|--|
| <p>5</p> | <p>Бусад асуудал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгийн журамд нэмэлт оруулах тухай</li> <li>- Зарим хүмүүсийг "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнуулах тухай</li> </ul> | <p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 2.2.9-д заасныг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан "Журам батлах тухай" тогтоолын нэгдүгээр хавсралт "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-д "6.3. "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдэг, үнэмлэхийг өөрийн буруугаас хаяж үрэгдүүлсэн буюу гэмтээсэн тохиолдолд тухайн шагнагдсан хүнийг шагналд тодорхойлсон байгууллагын албан тодорхойлолт, өөрийнх нь хүсэлтийг үндэслэн нэг удаа үнийг нь төлүүлж солих буюу дахин олгож болно" гэж нэмж оруулах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан нэр бүхий 8 төрийн албан хаагчийг Монгол Улсын "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах</p> <p>2. Шагнагдсан хүн тус бүрийн тэмдгийг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 1 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 4.2-т заасны дагуу тухайн байгууллагаас олгох.</p> |
|----------|--|--|

|  |  |   |
|--|--|---|
|  |  | 3. Шагнагдсан нийт төрийн албан хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүсэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
|--|--|---|

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ